



ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК



ToC

МОНГОЛ УЛСЫН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГМИЙН
ХАРИУЦАГЧИЙН ХӨТӨЛБӨР



БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГМИЙН
ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН СИСТЕМ

ХАРИЛЦАГЧИЙН
ГАРЫН АВЛАГА

Байгаль орчин, нийгмийн хариуцлагын бодлого яагаад хэрэгтэй вэ?

Байгаль орчин, нийгэмд ээлтэй бизнесийн үйл ажиллагаа эрхэлж, байгаль орчин, нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, түүнээс сэргийлэх замаар урт хугацаанд тогтвортой хөгжих нь дэлхийн улс орнуудын тогтвортой хөгжлийн чухал зорилт болоод байна. Энэ хүрээнд байгалийн нөөцийг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг хангах, нийгмийн бүхий л давхаргад санхүүгийн үйлчилгээг хүртээмжтэй байлгах, компаниудын нийгмийн хариуцлагыг дээшлүүлэх гээд олон асуудал багтдаг.

Хөгжингүй орнуудын туршлагаас харахад дээрхи зорилтод хүрэхэд банк, санхүүгийн салбар чухал үүрэгтэй оролцдог байна. Банк нь харилцагчид олгох санхүүжилтээрээ дамжуулан, зээлийн эрсдэлийг үнэлэх, бууруулах үйл явцтай адил зарчмаар харилцагчдынхаа байгаль орчин, нийгэмд учруулж болзошгүй эрсдэлийг тодорхойлж, үнэлэх улмаар тэдгээр эрсдэлээс үүсч болох санхүүгийн хор хохирлоос харилцагчийг хамгаалах, нийгмийн хариуцлагаа хэрэгжүүлэх чиглэлээр хамтран ажилладаг юм.

ХХБ-ны *БОНЭУС-ийн тухай

ХХБ нь Нидерландын хөгжлийн банктай хамтран 2012 оноос Байгаль орчин, нийгмийн хариуцлагын бодлого, зээлдэгчийн байгаль орчин, нийгмийн эрсдэлийн түвшинг үнэлэх үнэлгээний сүүлийн үеийн арга аргачлал, эрсдэл ба хяналтын тогтолцооноос бүрдсэн БОНЭУС-ийг Монголдоо нэвтрүүлэн ажиллаж байна.

Энэхүү систем нь хэрэглээний зориулалттай зээлээс бусад бизнесийн зээлийн хүсэлтэнд хамаарах ба бизнес эрхлэгч таны байгаль орчин, нийгмийн эрсдэлийг бид тодорхойлж, тантай хамтран эрсдэлээс сэргийлэх юм.

- *БОНЭУС - Байгаль орчин, нийгмийн эрсдэлийн удирдлагын систем
- **БОНХ - Байгаль орчин, нийгмийн хариуцлага
- ***БОНЭ - Байгаль орчин, нийгмийн эрсдэл
- ****ХАБЭА - Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй
- *****БОЭУМС - Байгаль орчин, эрсдэлийн удирдлагын менежментийн систем

****БОНХ-ын бодлогыг хэрэгжүүлсний ач холбогдол**

БОНХ-ын бодлогыг хэрэгжүүлснээр Банкинд, Харилцагч байгууллагад, Байгаль орчин, нийгэмд дараах давуу талууд бий болж байна.

Банкинд:

- Олон улсын шилдэг банкуудын туршлагыг Монголд хэрэгжүүлэх;
- Зээлийн эрсдэл буурах;
- Байгаль орчин, нийгэмд учрах эрсдэлийг бууруулах, улмаар улс орны тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулах;

Харилцагчид:

- Төлөвлөөгүй зардал болон эрсдэлээс урьдчилан сэргийлэх. Үүнд:
 - Үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлэх, түүнээс гарах зардал, эрсдэлээс сэргийлэх;
 - Компанид учирч болзошгүй олон нийтийн эсэргүүцлээс гарч болох зардал, эрсдэлээс сэргийлэх;
 - Зөвшөөрөгдөөгүй үйл ажиллагаа, чанарын шаардлага хангаагүй бүтээгдэхүүн, үйлчилгээ зэргээс үүдсэн төрийн байгууллагын торгуулиас сэргийлэх;
- Ногоон технологи ашиглаж, эрчим хүч, түүхий эдээ хэмнэх замаар үйл ажиллагааны зардлаа бууруулах;
- Зохистой техник, технологи ашиглаж, хог хаягдлаа багасгах, үйлдвэрлэлийн гарцыг нэмэгдүүлэх, ажилчдын ажиллах таатай орчныг бүрдүүлж, бүтээмжийг нэмэгдүүлэх, орлого ашгаа нэмэгдүүлэх;
- Хямд хүүтэй зээл, санхүүжилт авах боломжтой болох;
- Олон нийтэд танай компанийн нэр хүнд өсөх, эерэг хандлага бий болж, орлого, ашиг нэмэгдэх;
- Улс орны тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулах;

Байгаль орчин, нийгэмд:

- Ус, хөрс, агаарын бохирдол буурах;
- Цаг уурын өөрчлөлт багасгах;
- Ховордсон ан амьтан, ургамлыг хамгаалах;
- Түүх, соёлын өвийг хамгаалах;
- Хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн асуудлууд багасгах;

ХХБ харилцагчийн *БОНЭ-ийг хэрхэн зээлийн шийдвэр гаргалтандаа харгалзаж үздэг вэ?**

ХХБ нь зээл олгохдоо харилцагчийн байгаль орчин, нийгэмд нөлөөлөх сөрөг нөлөөллийг дараах үе шатаар үнэлж, хянадаг.

Харилцагчийг сонгох/эхний байдлаар шалгах	БОНЭ-ийг үнэлэх & Шийдвэр гаргах	Зээлийн гэрээ байгуулах	Эргэн хянах
<ul style="list-style-type: none"> Хориотой үйл ажиллагааны жагсаалт Анхан шатны үнэлгээ Байгаль орчин, нийгмийн эрсдэлийн ангилал /УЛААН, ШАР, НОГООН/ ХХБ-наас тавьсан БОНЭ-ийн шаардлагуудыг биелүүлэх боломжтой, хүсэлтэй эсэх 	<ul style="list-style-type: none"> Нарийвчилсан үнэлгээ Үйл ажиллагаатай танилцах БОНЭ-ийн шинжилгээ Нөхцөл шаардлага тавих Зээлийн хорооноос БОНЭ-ийг харгалзан зээл олгох эсэхийг шийдвэрлэнэ 	<ul style="list-style-type: none"> БОНЭ-ийн нөхцөл шаардлагыг зээлийн гэрээнд тусгана Шаардлагатай тохиолдолд БОНЭ-ийг бууруулах үйл ажиллагааны төлөвлөгөөг зээлийн гэрээнд хавсаргана 	<ul style="list-style-type: none"> Тодорхой давтамжтайгаар үйл ажиллагаатай танилцаж, эргэн хянах Нөхцөл, шаардлагын биелэлтийн тайлан

“Хориотой үйл ажиллагааны жагсаалт” буюу ямар төрлийн бизнест бид зээл олгохгүй вэ?

- Биологийн төрөл зүйлийн нөөц болон соёлын өвийн хамааралтай тухайн орны хууль тогтоомж болон олон улсын конвенциор хориглосон аливаа үйлдэл;
- Олон улсад хориглосон буюу тухайн орны хууль тогтоомж, олон улсын конвенциор хууль бус гэж үзэгддэг үйл ажиллагаа, үйлдвэрлэл худалдаа;
- Ховордсон ургамал амьтанг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенцид багтах зэрлэг амьтны болон ургамлын аймгийг худалдаалах;
- Байлдааны, зэр зэвсгийн худалдаа, бүтээгдэхүүн;
- Согтууруулах ундааны үйлдвэрлэл, худалдаа (пиво, дарснаас бусад);
- Тамхины үйлдвэрлэл, худалдаа;
- Мөрийтэй тоглоом, казино болон түүнтэй адилтгах байгууллагууд;
- Садар самуун явдал, биеэ үнэлэхийг дэмжсэн аливаа бизнес;

- Цацраг идэвхит бодисын материал үйлдвэрлэл, худалдаа;
- Албадан хөдөлмөрлөлт, хүүхдийн хөдөлмөрийн мөлжлөг ашиглан үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн буюу үйл ажиллагаа
- Ойжуулалтын тогтвортой удирдлаган дор хөгжүүлж байгаа ой модоос бусад газарт мод болон бусад ойн гаралтай бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх буюу тэдгээрийг худалдаалах;
- Холбогдох экспорт, импорт болон транзит орнуудаас авсан шаардлагатай экспорт, импортын гэрчилгээгүй, эсхүл дамжин өнгөрүүлж тээвэрлэх зөвшөөрөлгүй барааг наймаалцах;

Харилцагчийн бизнес үйл ажиллагаа /эрсдэлийн түвшингээр/

“Хориотой үйл ажиллагааны жагсаалт”-нд ороогүй харилцагчдын БОНЭ-ийг олон улсын стандартад нийцсэн аргачлалаар үнэлж, эрсдэлийг тодорхойлно.



Нарийвчилсан үнэлгээ хийхэд зээлдэгчээс нэмэлт материал шаардаж болно. Үүнд:

- Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, эрх бүхий байгууллагын дүгнэлт /ажлын байр, бүтээгдэхүүний чанар, гарал үүслийн гэрчилгээ, эрүүл ахуйн гэрчилгээ гэх мэт/
- Бүтээгдэхүүний тохирлын гэрчилгээ, стандартууд
- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, тайлан, төлөвлөгөө,
- Байгаль орчны бодлого
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн журам, зааварчилгаа, төлөвлөгөө, яаралтай тусламжийн төлөвлөгөө
- Компанийн нийгмийн хариуцлагын бодлого, үйл ажиллагааны төлөвлөгөө
- Хөдөлмөрийн дотоод журам, хүний нөөцийн бодлого гэх мэт

Бид ***БОЭУМС-ийн чиглэлээр бид юу хийсэн бэ?**

2012 он

- ХХБ-ны БОНЭУС-ийг боловсруулах ажлыг эхлэв.
- Зээлийн ажилтнууд болон байгаль орчин, нийгмийн эрсдэлийн шинжээч нарыг сургаж, мэргэшүүллээ.
- PwC олон улсын зөвлөх компанийн дэмжлэгтэйгээр БОНХ-ын бодлого, заавар, журмууд, зээлдэгчийн БОНЭ-ийн түвшинг үнэлэх үнэлгээний сүүлийн үеийн арга аргачлал, эрсдэл ба хяналтын тогтолцооноос бүрдсэн БОНЭУС-ийг бий болгож албан ёсоор хэрэгжүүлж эхэлсэн.

2013 он

- БОНЭУС-ийн хэрэгжилтэд PwC байгууллагаар олон улсын хөндлөнгийн аудит хийлгэсэн.
- Нидерландийн хөгжлийн банк болон Монголын Банкны Холбоотой хамтран Монгол улсад анх удаа “МУ-ын Тогтвортой Санхүүжилтийн форум”-ыг зохион байгуулсан.
- Монгол Улсын “Тогтвортой Санхүүжилт” хөтөлбөрт нэгдэн орсон.

2014 он

- БОНЭУС-ийн хүрээнд ХХБ-ны ажилтнууд дотоодын болон олон улсын сургалтуудад хамрагдлаа.
- Олон улсын туршлагатай дотоодын байгаль орчны зөвлөх байгууллагуудтай хамтын ажиллагаагаа эхлүүлсэн.
- Эдийн засгийн салбар бүрийн хувьд БОНЭ-үүдийг тодорхойлж, түүнийг бууруулах, хянахад чиглэгдсэн баримт бичгүүд, зээлийн ажилтны гарын авлага болон харилцагчид тавих нэмэлт нөхцөл шаардлагуудыг шинэчлэн боловсруулав.

2015 он

- ХХБ-ны зарим АТМ-ууд өндөр настан, бичиг үсэг мэдэхгүй болон харааны бэрхшээлтэй иргэдэд тусгайлан зориулж, "ярьдаг" болсон. Харилцагчид АТМ-аар үйлчлүүлэхдээ АТМ-д байрлах чихэвчний оролтонд өөрийн чихэвчээ холбосноор АТМ "ярьж" эхлэнэ.
- Банкны Төв байр болон шинээр нээж буй бүх салбарууддаа тэргэнцэртэй иргэдэд зориулсан зам, гарц, зогсоолыг бий болгосоор байна.
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэн, жирэмсэн болон өндөр настнууддаа банкны бүх салбараар дараалал харгалзахгүй үйлчилдэг боллоо.
- Харааны бэрхшээлтэй иргэн, өндөр настан, бичиг үсэггүй иргэдэд банкны үйлчилгээг хүртээмжтэй хүргэх зорилгоор АТМ-уудыг бий болгож, мөн www.tdbm.mn вэб хуудсаа дээрх иргэдэд нээлттэй болгов.

Цаашид ХХБ нь БОНЭУС- ээ тогтмол хөгжүүлэн сайжруулж, олон улсын тэргүүн туршлагуудыг хэрэгжүүлэн, харилцагч Таныг эрсдэлээс хамгаалж, эдийн засгийн тогтвортой хөгжлийг дэмжин, ирээдүй хойч үедээ эрүүл орчныг өвлүүлэхээр ажиллах болно.

